

“ГУТАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024.04.11

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН нь:

“Гутал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал 2024.04.11-ны өдрийн 10⁰⁰ минутанд “Гутал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн өрөөнд эхлэв.

Тус хуралд:

1. Ц.Төмөр- биечлэн
2. Т.Билэгт- итгэмжлэлээр
3. Б.Батбилэг- биечлэн
4. Б.Баттөр - биечлэн
5. Б.Батхишиг- биечлэн
6. Р. Цэвээн- биечлэн тус тус оролцсон.

ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч Б.Жаргал хуралд оролцохоор ирсэн.

Хурлын ирц:

Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн хуралд 1,502,337 ширхэг хувьцаа эзэмшдэг 6 хувьцаа эзэмшигч оролцсон ба нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны 95.38 хувь болж байгаа.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах;
2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсвийг батлах;
4. 2023 оны ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний үндэслэлийг танилцуулах.
5. Компанийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг танилцуулах;

Хурал даргалагч: ТУЗ-ийн дарга Б.Батбилэг

СОНССОН нь:

Батбилэг: Сайн байцгаана уу. Өнөөдрийн хурал эхэлснийг мэдэгдье. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц бүрдсэн тул хэлэлцэх асуудлуудаа хэлэлцээд явъя.

Гутал ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг та бүхэнд цаасаар болон файл хэлбэрээр тараасан. Үүнтэй та бүхэн сайн танилцсан байхаа. Эхний хэлэлцэх асуудал Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах байгаа.

ТУЗ-ийн зүгээс дүгнэлтээ 2024 оны 02-р сарын 22-ны өдөр гаргасан. Үүн дээр хэлэх санал байна уу.

Төмөр: Санал байхгүй.

Хуралд оролцсон бүх хувьцаа эзэмшигчид 100 хувийн саналаар батлав.

Батбилэг: Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох асуудлаа ярилцъя. ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооноос 2024 оны 02-р сарын 14-ний өдөр хуралдаж, нийт 14 хүний нэрийн дэвшүүлж байгаа. Нэр дэвшигч нарын танилцуулгатай та бүхэн танилцсан байхаа. Та бүхэн саналын хуудсаараа сонгох хүмүүсдээ саналаа өгнө үү.

ТУЗ-ийн гишүүнээр Ц.Төмөр, Б.Батбилэг, Т.Билэгт, Б.Баттөр, Б.Батхишиг, Ч.Цэцэгмаа, хараат бус гишүүнээр Э.Билгүүн, Б.Жаргал, С.Бат-Эрдэнэ нар сонгогдлоо. Баяр хүргэе.

Одоо компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсвийг батлах асуудал байна. Жил бүрийн ТУЗ-ийн төсөв хувьцаа эзэмшигчдийн хурлаас батлагддаг. Энэ жилийн тухайд төсөв нийт 141,900,000 төгрөг байна. ТУЗ-ийн нарийн бичигийн даргын цалин хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага төлөвлөгдсөн байх тул үүнийг 800,000 төгрөг болгон нэмэгдүүлэх тусгай саналтай байна. Иймд ТУЗ-ийн нийт төсөв 144,300,000 төгрөг болж байна. Та бүхэн саналаа өгнө үү.

Төмөр: Санал байхгүй. Дэмжиж байна.

Баттөр: Дэмжиж байна.

Батхишиг: Татгалзах зүйл байхгүй. Дэмжиж байна.

Батбилэг: Дэмжиж байна. ТУЗ-ийн төсөв ийнхүү батлагдлаа. Дараагийн хэлэлцэх асуудал бол 2023 оны сүүлийн хагас жилийн ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний үндэслэлийг танилцуулах гэж байна. Бид ТУЗ-ийн 2024 оны 02-р сарын 07-ны өдөр 2023 оны сүүлийн хагас жилийн ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргасан. 2023 оны үйл ажиллагааны ашгаас нэгж хувьцаанд 1,400 /нэг мянга дөрвөн зуу/ төгрөгийн ногдол ашиг хуваарилах шийдвэрлэсэн болно.

Хамгийн сүүлийн хэлэлцэх асуудал бол Компанийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг танилцуулах юм. Аудитын компаниар “Сэрэлт дөл аудит” ХХК ажилласан ба аудитын дүгнэлттэй та бүхэн танилцсан байхаа.

Та бүхэн одоо санал хураах хуудсаа үнэн зөв, алдаагүй бөглөж өгнө үү. Тооллогын комисс тооцоог нь гаргаж танилцуулах болно.

Өнөөдрийн гаргасан шийдвэрүүдийг танилцуулав. Өнөөдрийн хурал дууслаа. Баярлалаа.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Дараах шийдвэрийг өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар гаргав. Үүнд:

1. Компанийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар батлав.
2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгов.

1. Б.Батбилэг
2. Б.Баттөр
3. Б.Батхишиг
4. Ц.Төмөр
5. Т.Билэгт
6. Ч.Цэцэгмаа

3. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгов.


1. Э.Билгүүн
2. Б.Жаргал
3. С.Бат-Эрдэнэ

4. "Гутал" ХК-ийн 2024 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг 1 дүгээр хавсралтын дагуу 100 хувийн саналтай батлав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 11:00 цагт дуусав.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

НАРИЙН БИЧИГ О.МАРАЛ-ЭРДЭНЭ



ХЯНАСАН:

ХУРЛЫН ДАРГА Б.БАТБИЛЭГ

